



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/44

Баян-Өндөр сум

Арга хэмжээ зохион байгуулж, хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөрөнгө гаргах тухай” А/346 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг төрөлжсөн мэргэжлийн лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан удирдамжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагааны төсөв болох 3.000.000 (гурван сая) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Г.Отгонцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
05 сарын 09-ны өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ ҮЗЛЭГИЙН УДИРДАМЖ

2026.05.08

Орхон аймаг

Үндэслэл: Монгол Улсын хэмжээнд 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй 14,600 орчим хүүхэд байгаагийн 16 орчим хувь (14.6 мянган хүүхэд / 2395) нь аутизмын хүрээний эмгэгтэй гэсэн тооцоо бий. Аутизмтай хүүхдийн тоо 2026 онд 3566 хүрсэн гэх мэдээлэл байх бөгөөд энэ нь өмнөх онуудаас өссөн үзүүлэлт юм. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 481 хүүхэд байна. Үүний дийлэнх буюу 52 хувийг ДЦП, уналт таталт, саа саажилт, эпилепси аутизм өвчнүүд эзэлж байна. Үүнтэй холбоотойгоор “Эрхэм нандин сувд” ТББ-аас 5 оношийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран бүсчилсэн байдлаар хөдөө орон нутгийн алслагдсан сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг жил бүр зохион байгуулдаг. Орхон аймгаас дээрх үзлэгт 2024 онд 18, 2025 онд 25 нийт 43 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамрагдаж идэвхитэй хяналтад байна.

Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо, шаардлагатай шинжилгээнд үе шаттайгаар хамруулж, эрт илрүүлэг, онош баталгаажуулалт, цаашдын эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад оршино.

Хамтран ажиллах байгууллага:

Орхон аймгийн Засаг даргын тамгын газар- Нийгмийн бодлогын хэлтэс

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

Эрхэм нандин сувд ТББ

Хамрах хүрээ: Хөгжлийн бэрхшээлтэй 25 хүүхэд

Хугацаа: 2026 оны 05 дугаар сарын 9-ний өдөр

Хаана: Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хийгдэх үзлэг, шинжилгээ:

Хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг Үүнд: Нүд, Шүд, Чих хамар хоолой, Мэдрэл, Сэтгэцийн эмч, сэтгэлзүйч, Зүрх, АЭЭСТ(уушиг) ХБЭСТ /дотор/, Бөөр, Ерөнхий мэс засал, Сэргээн засах, Хэл засал, Өсвөр үе, Удам зүй, Харшил судлал, Цусны эмгэг судлал, Түнх, Үе мөч, Ревматология, Мэдрэлийн мэс засал, бусад шинжилгээ

Хүлээгдэж буй үр дүн:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд бүрэн хамрагдан, эрүүл мэндийн нарийвчилсан үнэлгээ хийгдэнэ.
- Шаардлагатай нэмэлт шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулагдана.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, орон нутгийн хүүхдүүд төвийн нарийн мэргэжлийн тусламжид хамрагдах боломж нэмэгдэнэ.
- Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн өвчний онцлог, цаашдын асаргаа, сувилгаа, сэргээн засах арга хэмжээний талаар мэргэжлийн зөвлөгөө өгөгдөнө.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, хяналт, цаашдын тасралтгүй тусламж үйлчилгээний уялдаа холбоо сайжирна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд хэвтэн эмчлүүлсэн байна.

БОЛОВСРУУЛСАН: УАУСЗТҮХБИАХМ

ХЯНАСАН: ЭТЧЭМИХАМ



Т.НАРАНТУЯА

П.ХИШГЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
05 сарын 26-ны өдрийн
1/4 тушаалын хоёрдугаар хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН НАРИЙН
МЭРГЭЖЛИЙН ЭМЧИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ ҮЗЛЭГИЙН ТӨСӨВ**

№		Нэр төрөл	Хүн/ өдөр	нэгж үнэ	Нийт үнэ
1	Автобус түрээс	Жолоочийн хөлс Тээвэр шатахуун	Нийт 34 /2 өдөр/	30,000	3,000,000
Нийт					3,000,000

ТӨСВИЙГ БОЛОВСРУУЛСАН: УАУСЗТҮХБИАХМ

ТӨСВИЙГ ХЯНАСАН: ЭТЧЭМИХАМ

Т.НАРАНТУЯА

П.ХИШГЭЭ